



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН  
ГУРВАН ТАЛТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот  
Утас: 51-263035

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг  
шинэчлэн тогтоох тухай

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 3929 төгрөг буюу сард 660000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.
2. 2025 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 01-ний дотор шинэчлэн тогтоохоор шийдвэрлэсүгэй.
3. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах салбарын холбоод салбарын болон салбар дундын хэлэлцээрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харилцан зөвшилцөж нэмэгдүүлэн тогтоохыг зөвлөсүгэй.

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА,  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙД



Х.БУЛГАНТУЯА

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ



С.ЭРДЭНЭБАТ

МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ, ЭЗДИЙН  
НЭГДСЭН ХОЛБООНЫ ДЭД  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Х.ГАНБААТАР